БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖЛИЙН
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА
.................. Б.ДАВААНЯМ

2023 оны ..10.. дугаар сарын ..06.. -ны өдөр

# “МЭДЬЕ, НЭГДЬЕ” АЯНЫ ХҮРЭЭНД НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 10 дугаар сарын 6-ны өдөр — Улаанбаатар хот

*Төлөвлөгөөний зорилго:* “Мэдье, нэгдье” аяны хүрээнд байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд ажлын үр нөлөөг дээшлүүлэх, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэхэд оршино.

*Хугацаа:* 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

*Хамрах хүрээ:* Байгууллагын хэмжээнд.

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл | Байгууллагын хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. |
| 1 | 3.1.Өөрийн байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж, олон нийтэд хүргэсэн байх; | Байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгах болон нийт ажилтан, албан хаагчдын ёс зүйтэй, шударга байлгах зорилгоор албан хаагч бүртэй “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г гаргуулан авах, мөн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийг боломжит хэлбэрээр байгууллагын мэдээллийн самбар болон олон нийтэд түгээж ажиллах. | X/06-XI/02 | ЭБАТ Б.Орхонбайгаль,<br><br>Системийн ажилтан Д.Пүрэвдорж |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 3.2.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youmube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор байгууллагын цахим сайтад "Өдөр бүр нэг мэдээлэл" гэсэн уриалга дор АТГ-аас гаргасан шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийн сурталчилгааг хийх, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах. | X/06-XI/02 | ЭБАТ Б.Орхонбайгаль,<br><br>Системийн зааварлагч Ө.Ариунжаргал |
| 3 | 3.3.Өөрийн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах ажлын хүрээнд албан хаагч бүртэй "Хариуцлагын гэрээ"-г байгуулж, "Ёс зүйн мэдэгдэл"-ийг гаргуулан авах ажлыг байгууллагадаа зохион байгуулах. | X/06-XI/02 | Байгууллагын "Ёс зүйн дэд хороо"-ны дарга Д.Сайнхүү,<br><br>ЭБАТ Б.Орхонбайгаль |
| 4 | 3.4.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м холбогдох арга хэмжээг зохион байгуулах. | Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын байдалд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн үнэлгээг байгууллагадаа зохион байгуулах. | X/06-XI/02 | Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Энхзул |
| 5 | 3.5.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн зөрчилгүй, чанар, үр дүнг сайжруулсан байх. | Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох тал дээр анхаарч ажиллах. | X/06-XI/02 | Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Г.Энхзул,<br><br>Архив, бичиг хэргийн ажилтан Б.Цогтбаяр |
| 6 | 3.6.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах. | Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөн ажиллах. | X/06-XI/02 | Нийт албан хаагчид |
| 7 | 3.7.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байх. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд шаардлагатай шийдвэр болон мэдээ, мэдээллийг тогтмол оруулж ажиллах. | X/06-XI/02 | ЗТСХ-ийн ахлах мэргэжилтэн Г.Энхзул, |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | | | | ЗТСХ-ийн ахлах мэргэжилтэн Б.Орхонбайгаль,<br><br>ТХЗХ-ийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батнавч,<br><br>Ахлах нятлан бодогч Б.Бэхжаргал |
| 8 | 3.8.Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх. | Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор АТГ-аас холбогдох чиглэлийн дагуу сургалтыг зохион байгуулж, уулзалт хэлэлцүүлгийг байгууллагадаа зохион байгуулах. | X/06-XI/02 | ЭБАТ Б.Орхонбайгаль |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Б.ОРХОНБАЙГАЛЬ

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САЙНХҮҮ

## “МЭДЬЕ, НЭГДЬЕ” АЯНЫ ХҮРЭЭНД НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАРТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 11 дугаар сарын 01-ний өдөр — Улаанбаатар хот

*Төлөвлөгөөний зорилго:* “Мэдье, нэгдье” аяны хүрээнд байгууллагын хэмжээнд Авлигаас урьдчилан сэргийлэх хүрээнд ажлын үр нөлөөг дээшлүүлэх, албан хаагчдын ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдлэг, харилцаа, хандлагыг нэмэгдүүлэх, ур чадварыг сайжруулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх, байгууллагын үйл ажиллагааны чадавхыг дээшлүүлэхэд оршино.

*Хугацаа:* 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулна.

*Хамрах хүрээ:* Байгууллагын хэмжээнд.

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл | Байгууллагын хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|
| 1. | 2. | 3. | 4. | 5. |
| 1 | 3.1.Өөрийн байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж, олон нийтэд хүргэсэн байх; | Байгууллагын үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байлгах болон нийт ажилтан, албан хаагчдын ёс зүйтэй, шударга байлгах зорилгоор албан хаагч бүртэй “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г гаргуулан авах, мөн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур) зэргийг боломжит хэлбэрээр байгууллагын мэдээллийн самбар болон олон нийтэд түгээж ажиллах. | Газрын даргын 2023 оны А/75 дугаар тушаалаар загвар баталж, байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчидтай “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г нь гарын үсгээр баталгаажуулан гаргуулан авсан.<br>Мөн байгууллагын мэдээллийн 3 самбар болон байгууллагын цахим хуудас болон ERP систем дээр Авлига болон авлигын эрсдэлээс ангид байлгах зорилгоор шторк, зурагт хуудас болон контент, цахим брошур зэргийг өөрийн байгууллагын боломждоо тулгуурлан олон нийтэд түгээж ажилласан болно. | 100% |
| 2 | 3.2.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг хэвлэл мэдээллийн | Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор байгууллагын цахим сайтад “Өдөр бүр нэг мэдээлэл” гэсэн уриалга дор АТГ-аас гаргасан шторк, зурагт хуудас, | Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах зорилгоор байгууллагын цахим сайтад 1 сарын туршид 14 удаа АТГ-аас гаргасан шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийг | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, инстаграм, youtube суваг), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх; | сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, брошур зэргийн сурталчилгааг хийх, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах. | байршуулж нийт давхацсан тоогоор 196 үзэлт, хандалтыг аваад байна. | |
| 3 | 3.3.Өөрийн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагуудад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх, сурталчлах арга хэмжээг зохион байгуулах. | Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах ажлын хүрээнд албан хаагч бүртэй "Хариуцлагын гэрээ"-г байгуулж, "Ёс зүйн мэдэгдэл"-ийг гаргуулан авах ажлыг байгууллагадаа зохион байгуулах. | Байгууллагын нийт 21 ажилтан, албан хаагчдыг Авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 09-ны өдөр "Хариуцлагын гэрээ"-г байгуулж, "Ёс зүйн мэдэгдэл"-ийг гаргуулан, баталгаажуулан авч, зохион байгуулалтын арга хэмжээг байгууллагадаа авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| 4 | 3.4.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м холбогдох | Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн өргөдөл, гомдлын байдалд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлэх эрсдэлийн үнэлгээг байгууллагадаа зохион байгуулах. | Байгууллагын хэмжээнд 2023 оны 3-р улирлын байдлаар нийт 57 өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс эх үүсвэрээр нь ангилбал Засгийн газрын 11-11 төвийн дугаараас **22**, eservice.mn системээр **4**, 1800-1200 тусгай дугаараас **9**, НҮНТ-өөр **1**, smartcar системээр **9**, онлайн бизнес төв системээр **1**, хүний нөөцтэй холбоотой **11** өргөдөл, санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл гомдол, санал хүсэлт байхгүй байна. Байгууллагад ирсэн гомдол, санал, хүсэлтүүдийн шийдвэрлэлтэд дүн | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | арга хэмжээг зохион байгуулах. | | шинжилгээ хийхэд цар хүрээнээс хамаарч шийдвэрлэлтийн хугацаа харилцан адилгүй байна. Иргэн аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт өргөдөл гомдлыг агуулгаар нь авч үзвэл нийслэлээс хэрэгжүүлж буй eservice.ulaanbaatar.mn системийн өргөдөл гомдол гаргах цэс нь ажиллахгүй, Тээврийн хэрэгслийн нэгдсэн цахим үйлчилгээний www.Smartcar.mn системийн ажиллагаа болон автотээврийн хэрэгслийн татвар төлөлттэй холбоотой, Тээврийн хэрэгслийн цахим гэрчилгээ /RFID чип/ суурилуулахыг эсэргүүцсэн гомдлууд дийлэнх хувийг эзэлж байсан тул систем хариуцсан албан хаагчдад системийн хэвийн ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлж байгаа төслүүдийнхээ ач холбогдол давуу талуудыг зөв хүргэх чиглэлээр ажил зохион байгуулах талаар хэлтсийн дарга нарт үүрэг чиглэл өгч ажилласан. | |
| 5 | 3.5.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн зөрчилгүй, чанар, үр дүнг сайжруулсан байх. | Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох тал дээр анхаарч ажиллах. | Байгууллагын хэмжээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл гомдол, санал, хүсэлтийг **6** эх үүсвэрээс хүлээн авдаг бөгөөд 2023 он гарснаас хойш нийт **57** өргөдөл гомдол, санал, хүсэлт ирснээс Засгийн газрын 11-11 төвийн дугаараас **22**, eservice.mn системээр **4**, 1800-1200 тусгай дугаараас **9**, НҮНТ-өөр **1**, smartcar системээр **9**, онлайн бизнес төв системээр **1**, хүний нөөцтэй холбоотой **11** өргөдөл, санал, хүсэлт ирсэн байна. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлэх хүрээнд байгууллагын и-мэйл support@ulaanbaatar.mn болон дижитал UB гар утасны аппликейшнаар гаргах боломжийг бүрдүүлсэн. Иргэд аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 12 хоног 7 цаг байсан бөгөөд "Мэдье, нэгдье" аяны хүрээнд хугацааг 9 хоног 11 цаг 53 минут болж бууруулсан үзүүлэлттэй байна. | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | 3.6.Байгууллагын төсөв, санхүүгийн сахилга, батыг сайжруулах. | Төсвийн хэмнэлтийн тухай хуулийг дагаж мөрдөн ажиллах. | Байгууллагын 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд төсвийн тухай хууль болон төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулж, 1 удаагийн тэтгэмж урамшуулал болон байгууллагынхаа хэмжээнд 1 принтер ажиллуулж бичгийн цаас, принтерийн хор гэх мэт өдөр тутам хэрэглэгдэх бичиг хэргийн зардлуудаа танаж, санхүүгийн гүйцэтгэлийн тайланг сар, улирлаар нэгтгэн тухай бүрт нь тайлагнаж ажилласан. | 100% |
| 7 | 3.7.Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байх. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд шаардлагатай шийдвэр болон мэдээ, мэдээллийг тогтмол оруулж ажиллах. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд https://shilendans.gov.mn/ цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр 16 нэр төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал, хагас жил, бүтэн жилээр гарган, цаг хугацаанд нь нээлттэй мэдээлж ажиллаж байна. Үүнд:<br>Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой санхүүгийн тайлан, цалингийн зардал, хандив тусламж төсөвт байгууллагын батлагдсан төсөв, зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагаанаас олсон орлого, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт зэрэг 9 төрлийн мэдээлэл хөрөнгө оруулалт тендертэй холбоотой хөрөнгийн зардал, тендерийн ерөнхий мэдээлэл, 5 саяас дээш худалдан авалтын мэдээлэл<br>Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой хийгдэж байгаа шууд худалдан авалт, нээлттэй тендерийн мэдээлэл, байгууллагын урсгал зардлаар гэрээ байгуулагдан хийгдсэн ажлуудыг Шилэн дансны тухай хуулийн дагуу сар бүрийн 7-ны дотор урсгал зардлаар хийгдсэн 8 ажлын мэдээ тайланг цаг алдалгүй оруулж ажилласан.<br>Байгууллагын бүтэц орон тооны өөрчлөлт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, | 100% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | | | 9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал үүсээгүй болох зэрэг мэдээ мэдээллийг сар бүрийн 08-ны дотор шилэн дансанд оруулан хавсаргах материалыг PDF файлаар хөрвүүлэн нээлттэй мэдээлсэн. | |
| 8 | 3.8.Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах чиглэлээр сургалт, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан байх. | Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор АТГ-аас холбогдох чиглэлийн дагуу сургалтыг зохион байгуулж, уулзалт хэлэлцүүлгийг байгууллагадаа зохион байгуулах. | Байгууллагын албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэгийг нэмэгдүүлэх, харилцаа, хандлагыг сайжруулах зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр АТГ-ын Сургалт, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамъянчойжилыг байгууллага дээрээ авчирч, 1 цагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан болно. | |
| 9 | Хэрэгжилтийн хувь: | | | 100% |

**ТАНИЛЦСАН:**
ГАЗРЫН ДАРГА Б.ДАВААНЯМ

**ХЯНАСАН:**
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Д.САЙНХҮҮ

**ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ГАРГАСАН:**
БАЙГУУЛЛАГЫН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН Б.ОРХОНБАЙГАЛЬ

“Мэдье, Нэгдье” аяны хүрээнд нийслэлийн
Цахим хөгжил, мэдээллийн технологийн
газарт зохион байгуулах арга хэмжээний
төлөвлөгөөний хэрэгжилтийн хавсралт

1.Байгууллагын 21 албан хаагчдаас баталгааг гаргуулан авсан байдал:



НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 02 өдөр    Дугаар А/75    Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дахь заалт, Авлигын эсрэг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоол, “Дүрэм шинэчлэн батлах тухай” нийслэлийн Засаг даргын 2023 оны А/795 дугаар захирамжаар шинэчлэн батлагдсан нийслэлийн “Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэрээ”-ний загварыг нэгдүгээр, “Ёс зүйн мэдэгдэл”-ийн загварыг хоёрдугаар, “Нууцын баталгааны батламж”-ийг гуравдугаар, “Ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх баталгаа”-г дөрөвдүгээр, “Хариуцлагын гэрээ”-г тавдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2.Батлагдсан загварын дагуу ажилтан, албан хаагч бүртэй гэрээг байгуулж, баталгааг гаргуулан газрын хэмжээнд үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлж, ажилтан хаагчдыг мэдээллээр хангах, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга Д.Сайнхүү, байгууллагын Эрх бүхий албан тушаалтан Б.Орхонбайгаль нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА    Б.ДАВААНЯМ



НЦХМТГ-ЫН ДАРГЫН 2023 ОНЫ А/75 ДУГААР ТУШААЛЫН
НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТААР БАТАЛСАН
**“АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГЭРЭЭ”-Г**
БАЙГУУЛСАН АЛБАН ХААГЧДЫН ЖАГСААЛТ

2023.10.09

| № | Овог, нэр | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|---|---|---|---|---|
| | | **нэг. Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс** | | |
| 1 | Д.Сайнхүү | Хэлтсийн дарга | | X/09 |
| 2 | Г.Энхзул | Хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн | | X/09 |
| 3 | Б.Орхонбайгаль | Хүний нөөц, сургалт хариусан ахлах мэргэжилтэн | | X/09 |
| 4 | Т.Оттонжаргал | Бодлого төлөвлөлт, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн | | X/09 |
| 5 | Б.Энхтулга | Хууль, эрх зүй, гэрээ хариуцсан ажилтан | | X/09 |
| 6 | Г.Цогтбаяр | Архив, бичиг хэргийн ажилтан | | X/24 |
| | | **хоёр. Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтэс** | | |
| 7 | Б.Чойжилсүрэн | Хэлтсийн дарга | | X/09 |
| 8 | Б.Туяацэцэг | Системийн төлөвлөлт, технологийн шийдэл хариуцсан ахлах мэргэжилтэн | | X/09 |
| 9 | Ц.Оюунсүрэн | Системийн загварчлал хариуцсан мэргэжилтэн | | X/09 |
| 10 | Ж.Хонгорзул | Системийн мэргэжилтэн | | X/09 |
| 11 | Б.Эрдэнэцэцэг | Орон зайн мэдээллийн систем, дата анализ хариуцсан ажилтан | | X/09 |
| 12 | Ө.Ариунжаргал | Системийн зааварлагч | | X/09 |
| 13 | Д.Пүрэвдорж | Системийн ажилтан | | X/09 |
| | | **гурав. Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтэс** | | |
| 14 | Н.Пүрэв | Мэдээллийн аюулгүй байдал, эрсдэл хариуцсан ахлах мэргэжилтэн | | X/09 |
| 15 | Г.Баяржаргал | Мэдээллийн сервер, өгөгдлийн сангийн аюулгүй байдал хариуцсан инженер | | |
| 16 | У.Даваацэрэн | Сүлжээний мониторинг, удирдлагын инженер | | X/09 |
| 17 | А.Оюун-Эрдэнэ | Хяналт удирдлагын системийн инженер | | X/09 |
| 18 | Э.Очбадрах | Дэд бүтцийн шинэчлэлт, төлөвлөлтийн инженер | | X/09 |



| № | Овог, нэр | Албан тушаал | Гарын үсэг | Огноо |
|---|---|---|---|---|
| 19 | Л.Ариунжаргал | Хяналтын камерын систем төлөвлөлтийн инженер | | X/09 |
| | | **дөрөв. Төслийн хэрэгжилт, зохицуулалтын хэлтэс** | | |
| 20 | Ц.Батнаеч | Төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтэн | | X/09 |
| | | **тав. Цахим шилжилт зохицуулалтын хэлтэс** | | |
| 21 | О.Мөнхбадрал | Цахим шилжилтийн нэвтрүүлэлтийн судалгаа, шинжилгээ хариуцсан инженер | | X/9 |

2.Байгууллагын мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудас, ERP системд байршуулан олон нийтэд түгээсэн байдал:









НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР
ТАНИЛЦУУЛГА
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ
ДҮРЭМ ЖУРАМ
БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ
ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР
МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ
ИЛ ТОД БАЙДАЛ
ХҮНИЙ НӨӨЦ
САНХҮҮ
ҮЙЛ АЖИЛЛАГАА
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
САНАЛ АСУУЛГА
САНАЛ ХҮСЭЛТИЙН ХАЙРЦАГ
it.ub.gov.mn
11-330822


Нийслэлийн Цахим хөгжил, Мэдээллийн технологийн газар
5хоног
Хараагүй Сонсоогүй Хэлгүй юм шиг явсаар л байх уу?
АВЛИГЫГ МЭДЭЭЛЬЕ
Нийслэлийн Засаг даргын тамгын газар
Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар
"МЭДЬЕ, НЭГДЭЕ" АЯН
Хараагүй
Сонсоогүй
Хэлгүй
юм шиг явсаар л байх уу?
110 залга
ТӨЛБӨРГҮЙ
АВЛИГЫГ МЭДЭЭЛЬЕ
Танаас гадна өөр 8 хүн
Нэг сэтгэгдэл


Нийслэлийн Цахим хөгжил, Мэдээллийн технологийн газар
1 цаг
✅Авлигыг мэдээлье✅
Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар
Монгол Улсын Авлигатай тэмцэх газар
110 залга
Авлигын эсрэг
НЭГДЬЕ
МЭДЭЭЛ

ъ


12:10
19%
erp.ulaanbaatar.mn
СИСТЕМҮҮД
Систем хариуцсан ажилтан
Н. ERP Admin
9 өдрийн өмнө
Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар
Аянд нэгдэж байна!
"МЭДЬЕ, НЭГДЭЕ" АЯН
Хараагүй
Сонсоогүй
Хэлгүй
ТӨЛБӨРГҮЙ
АВЛИГЫГ МЭДЭЭЛЬЕ
Нийт
Дэмжсэн 43
Сэтгэгдэл 1
Систем хариуцсан ажилтан
Н. ERP Admin
9 өдрийн өмнө
Материал хүлээн авах хугацаа: Хугацаа: 2023.10.11-ний өдрийн 08:00 цагаас –2023.10.18-ны өдрийн 17:00 цаг хүртэл
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531971166371
Идэвхтэй ажилтан: 2244

ERP-д


erp.ulaanbaatar.mn
СИСТЕМҮҮД
Нийт
Дэмжсэн 21
Сэтгэгдэл
Систем хариуцсан ажилтан
Н. ERP Admin
3 өдрийн өмнө
Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газар
АЯНД НЭГДЭЖ БАЙНА
110
НЭГ
МЭДЭЭЛ
Нийт
Дэмжсэн 14
Сэтгэгдэл

ERP-д

3.Авлигатай тэмцэх газраас гаргасан шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, гарын авлага, брошур зэргийг өдөр бүр байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн байдал :































4.Байгууллагын албан хаагчдыг аюлигаас ангид байлгах үүднээс Ёс зүй, Хариуцлагын гэрээ г.м гэрээ, баталгааг гаргуулан авсан байдал:



ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2023 оны 10 сарын 09 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот



ЁС ЗҮЙН МЭДЭГДЭЛ





АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГЭРЭЭ





АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС АНГИД БАЙХ БАТАЛГАА

5. АТГ-ын Сургалт, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар М.Жамъянчойжил байгууллагын нийт албан хаагчдад сургалт хийж буй байдал:





НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР